

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2022.11.29

Орхон аймаг

№	Заалт	Хэрэгжилт	Үнэлгээ
3.1	Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэх	<p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн албыг чадавхжуулах, нөөц бэлтгэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний сургаж, дадлагажуулах, тандалт хийж голомтыг цомхотгох хүрээнд дараах ажлуудыг хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ЭМС-ын А/165 “Коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж үзүүлэх түр орыг татан буулгах тухай” тушаалаар коронавируст халдвар (КОВИД-19)-тай иргэнд тусламж үзүүлж байсан хувийн хэвшлийн 5 эмнэлгийг татан буулгасан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт ковидыг эмчилж байна. Тайлант хугацаанд коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэнээс 1244 хүн хэвтэн эмчлүүлсэн. - Коронавируст халдвар илрүүлэх Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн. Лабораторийн чадавх өмнөх оноос 5%-иар нэмэгдэж 85% болсон байна. - Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3-р тунд 57,9%, 4-р тунд өссөн дүнгээр 15,5% иргэн хамрагдсан. - Коронавируст халдварын 5 дахь давлагааны үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний зураглал гарган иргэдэд мэдээ, мэдээлэл түгээн ажилласан. - Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр төвийн бүсийн зөвлөлдөх уулзалтад 7 аймгийн 39 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжууллаа. - Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 нэр төрлийн 289,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байна. Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн. - Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг иргэдэд төлөвлөлтийн дагуу орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон цахимаар хүргэн тогтмол хүргэн ажилласан. Тайлант хугацаанд 297 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан 310584 иргэнд түгээн ажилласан. Коронавируст халдварын орон нутгийн нөхцөл байдлын мэдээлэл 94 удаа, Коронавируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтын талаар 5 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, вакцины үр дүн, ач холбогдлыг таниулах ганцаарчилсан зөвлөгөөг 1479 хүнд, утсаар 2110 хүнд өгч ажилласан. 	90

		Төлөвлөгөөний хэрэгжилт 85% байна.	
3.2	Цар тахлын голомтыг хяналтад авах, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, удирдлага зохицуулалтыг сайжруулж, хяналт шалгалтыг чангатгах	Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын ковидын үеийн бэлэн байдал, халдвар хамгаалал, тусламж үйлчилгээний зохион байгуулалт, дархлаажуулалтын бэлэн байдал, дархлаажуулалтын үйл явцад 3 удаа хяналт хийж, зөвлөмжөөр ханган ажилласан. Коронавируст /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр 946 эмч мэргэжилтэн, ажилтан, нийт эрүүл мэндийн салбарын ажилчдын 61%-ийг сургалтад хамруулсан. Тус хугацаанд коронавируст халдвар илрүүлэх Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн. Батлагдсан нийт тохиолдлын ойрын хавьтлын 9548 иргэнд тандалт судалгаа хийсэн. Нийт 70 багц өвчлөл бүртгэгдсэнээс зөөвөрлөгдсөн 25, аж, ахуй нэгж байгууллага 26, найз нөхдийн 19, гэр бүл, хамаатан садны 35 багц өвчлөлийн голомтыг идэвхгүй болгосон.	90
3.8	Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн гамшиг, осолтой тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангах	Аймгийн шуурхай штабыг оперативын бүтцэд оруулж шинэчилсэн. ЭМГ-ын даргын А/09 дүгээр тушаалаар гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Нийт 17 бие бүрэлдэхүүнийг 6 бүтцээр хувааж тусгай зориулалтын мэргэжлийн ангийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн алба хаагчдыг томилсон. Эрүүл мэндийн газрын даргын нэрэмжит эрүүл мэндийн албан бэлтгэл бэлэн байдлыг шалгах үзлэг дадлага сургуулилтыг Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан. Бие бүрэлдэхүүний иж бүрэн хувцсыг 2,7 сая төгрөгөөр бэлтгэн жигдрүүлсэн. Гамшгийн үеийн чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулилтын үеэр танхимын сургалт 3 удаа, мэргэжлийн ангийн дадлага сургуулилтыг 4 удаа хийж, хээрийн эмнэлэг дэлгэж жагсаалын үзлэгт “Онц” үнэлгээгээр дүгнэгдсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах эрүүл мэндийн албаны эрүүл мэндийн албаны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 85%-тай байна.	90
3.17	Коронавируст халдварт өвчний үед хяналт тавьж ажиллахад шаардлагатай техник хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисоор хангахад дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн гамшгийн нөөцийг нэмэгдүүлж Эрүүл мэндийн яамнаас 5 удаагийн 885,3 сая төгрөгийн нөөц хангалт хийгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 690,3 /85,1%/ сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хэрэгсэл олгож нөөцийг нэмэгдүүлсэн. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцөд 12 нэр төрлийн 289,5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис байна. Байгаль орчин аялал, жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны А/25А/46А75 дагаар тушаалаар батлагдсан ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг үйл ажиллагаанд хэрэглэх зөвлөмж өгч, хяналт тавин ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын нөөц бүрдүүлэлт дунджаар 89,8%-тай, 54 хоногийн нөөцтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,1%-аар нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 95,5%, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 98%-тай байна Коронавируст халдвар илрүүлэх Бх-ПГУ шинжилгээг 10422 иргэнд хийснээс	90

		коронавируст халдварын 3988 тохиолдол бүртгэгдсэн. Лабораторийн чадавх өмнөх оноос 5%-аар нэмэгдэж 85% болсон байна. Хариу арга хэмжээний чадавх 90%, өнгөрсөн оны мөн үеэс 5%-аар нэмэгдсэн байна.	
3.19	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөлийг байгуулж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 25 сэдвээр сурталчилгааг цахим сүлжээнд байршуулж, сурталчилсан. Тайлант хугацаанд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сургалтад давхардсан тоогоор 1184 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеэр аймгийн шуурхай штабт 2022 оны эхний улирлыг дуустал ажилласан эмч, мэргэжилтнүүдэд Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу ажлын бус цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан мэргэжилтнүүдэд илүү цагаар бодож олгосон. Нийт 6 хүнд илүү цагийн 312000 төгрөгийг олгосон.</p> <p>Коронавируст халдвар /ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, голомтын болон шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх үед эрүүл мэндийн бүх ажилтнуудыг 100% халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжиж ажилласан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 31 ажилтан хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийг журамд заасан хувь хэмжээгээр тогтоолгосон. Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн хэвийн бус хортой нөхцөлд ажиллаж буй 112 эмч, эмнэлгийн ажилтан хорогдуулсан цагаар ажилласан ба 234 эмч эмнэлгийн ажилтанд хэвийн бус нөхцөлийн 10%-ийг олгосон. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолын дагуу эх барих эмэгтэйчүүд, эх баригч, хүүхэд, нярайн 83 эмч, сувилагчид үндсэн цалингийн 10%, сүрьеэгийн 14 эмч, сувилагч, үйлчлэгчид 30%-ийн хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг олгосон. Хүний нөөцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн байгууллагын нийт ажилчдын 92% нь урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар орсон байна. Мөн 40-ээс дээш насны 330 эрүүл мэндийн ажилтанд хавдрын маркер хийлгэж, 3 мэргэжилтнийг нарийн мэргэжлийн эмчид илгээсэн. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин бүртгэгдээгүй.</p>	90
3.22	Хүнсний аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарч хоол хүнсээр дамжих хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх	Тайлант хугацаанд гэдэсний халдварт өвчин 65 бүртгэгдсэнээс 38 буюу 58,4%-ийг хоолны хордлого, 25 буюу 38,5%-ийг цусан суулга, 3,1%-ийг салмонелл бусад халдвар эзэлж байна. Гэдэсний халдварт өвчин 10,000 хүн амд 6,1 промилл болж өнгөрсөн оны мөн үеэс 0,4 промиллоор буурсан. Хүүхдийн хооллолтын чиглэлээр 10 төрлийн сэдвээр мэдээлэл, зөвлөмжийг олон нийтийн цахим хуудсаар дамжуулан 11375 иргэнд хүргэсэн байна. Ерөнхий боловсролын сургуулиудад хоол зүйчийн орон тоог орлон гүйцэтгэж буй эмч нарт хоол, шим тэжээлийн ойлголт, мэдлэг олгох сургалтыг 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 150 эмчийг хамруулсан. Үдийн хоол үйлдвэрлэж буй сургуулийн тогооч нарт хоолны шим тэжээл, чанарыг сайжруулах зорилгоор “Хоол хүнсний илчлэг, шимт бодисын хэмжээг тооцох” сургалт зохион байгуулж 97 хүнийг хамруулсан. Дэлхийн хүнсний Аюулгүй байдлын өдрийг тохиолдуулан НҮБ-ын Хүнсний хангамж, аюулгүй байдлаас зохион байгуулсан 3 удаагийн цуврал вебинарт 52 эмч, тогоочийг хамруулсан. Хоол хүнсээр дамжих хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх	90

		чиглэлээр Номин, ETV, Тусгал телевизүүдэд мэдээлэл хийгдсэн.	
3.33	Төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, ажиллагсдыг орон сууцжуулах зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ажиллагсдыг хамруулахад дэмжлэг үзүүлэх	Тайлант хугацаанд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, нийт 170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Нэн шаардлагатай хүүхдийн мэс засал, компьютер томограф соронзон давтамжит дүрс оношилгоо судлалаар улсын төсвийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2 эмчийг сургалтад хамруулсан. БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байгаа ба “Эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-ээс эхлүүлж 16 сувилагч элсэн суралцаж байна. Докторын зэрэгтэй эмч 0,2%, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 12%-тай байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9% нь хамрагдсан байна. Эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан аймгийн Засаг даргын тамгын газраас түрээсийн орон сууцаар хангагдсан байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 40 ажилтан зах зээлийн ханшнаас хөнгөлөлттэй үнээр буюу м/кв нь 1,350.000 төгрөг байхаар гэрээ байгуулсан бөгөөд одоогоор барилгын гүйцэтгэл 20%-тай явагдаж байна. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медикал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон байна. Нийгмийн дэмжлэгт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна.	90
Хэрэгжилтийн дундаж хувь 90%			

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХШУДАХМ

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ